МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН 2022 ОНЫ ЭЭЛЖИТ БУС ЧУУЛГАНЫ ТӨРИЙН БАЙГУУЛАЛТЫН БАЙНГЫН ХОРООНЫ 08 ДУГААР САРЫН 25-НЫ ӨДӨР /ПҮРЭВ ГАРАГ/-ИЙН ХУРАЛДААНЫ ТОВЬЁГ

№	Баримтын агуулга	Хуудас
1.	**Хуралдааны товч тэмдэглэл:**	1
2.	Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл	2-3
	1.Монгол Улсын Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийн төсөл /Улсын Их Хурлын гишүүн Н.Энхболд нарын 62 гишүүн 2022.08.25-ны өдөр өргөн мэдүүлсэн, хоёр дахь хэлэлцүүлэг/	2-3

Монгол Улсын Их Хурлын 2022 оны ээлжит бус чуулганы Төрийн байгуулалтын байнгын хорооны 08 дугаар сарын 25-ны өдөр /Пүрэв гараг/-ийн хуралдааны товч тэмдэглэл

Төрийн байгуулалтын байнгын хорооны дарга Ж.Мөнхбат ирц, хэлэлцэх асуудлын дараалыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 19 гишүүнээс 13 гишүүн хүрэлцэн ирж, 68.4 хувийн ирцтэйгээр хуралдаан 15 цаг 13 минутад Төрийн ордны "Жанжин Д.Сүхбаатар" танхимд эхлэв.

Томилолттой: Б.Пүрэвдорж;
Чөлөөтэй: Ж.Батсуурь, Г.Занданшатар, Ж.Эрдэнэбат;
Эмнэлгийн чөлөөтэй: А.Адъяасүрэн.

Нэг.Монгол Улсын Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийн төсөл */Улсын Их Хурлын гишүүн Н.Энхболд нарын 62 гишүүн 2022.08.25-ны өдөр өргөн мэдүүлсэн,* ***хоёр дахь хэлэлцүүлэг****/*

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн дарга Ц.Батбаатар, мөн хэлтсийн Төрийн байгуулалтын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Б.Хатантуул, референт Э.Баттогтох нар байлцав.

Төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Ж.Мөнхбат Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Байнгын хорооны хуралдаанаар 1 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 03 минут үргэлжилж, 19 гишүүнээс 13 гишүүн хүрэлцэн ирж, 68.4 хувийн ирцтэйгээр 15 цаг 16 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:
ТӨРИЙН БАЙГУУЛАЛТЫН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА Ж.МӨНХБАТ

Тэмдэглэл хөтөлсөн:
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ ХӨТЛӨХ
АЛБАНЫ ШИНЖЭЭЧ П.ОЮУНГЭРЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН 2022 ОНЫ ЭЭЛЖИТ БУС ЧУУЛГАНЫ ТӨРИЙН БАЙГУУЛАЛТЫН БАЙНГЫН ХОРООНЫ 08 ДУГААР САРЫН 25-НЫ ӨДӨР /ПҮРЭВ ГАРАГ/-ИЙН ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Ж.Мөнхбат: Байнгын хорооны гишүүдийн дийлэнх олонх хүрэлцэн ирсэн тул Байнгын хорооны ирц бүрдсэн байна.

2022 оны 08 дугаар сарын 25-ны өдрийн Төрийн байгуулалтын байнгын хорооны хуралдаан нээснийг мэдэгдье.

Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя.

Монгол Улсын Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийн төсөл. Улсын Их Хурлын гишүүн Нямаагийн Энхболд нарын 62 гишүүн 2022 оны 08 дугаар сарын 5-ны өдөр өргөн мэдүүлсэн, хоёр дахь хэлэлцүүлэг хийнэ.

Хэлэлцэх асуудалд саналтай гишүүн байна уу. Алга байна.

Хэлэлцэх асуудалдаа оръё.

Монгол Улсын Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийн төслийн хоёр дахь хэлэлцүүлгийг явуулъя.

Түрүүн дурдсан Нямаагийн Энхболд нарын гишүүн 62 гишүүн өргөн мэдүүлсэн. Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах журмын тухай хуулийн 18.3-т Төрийн байгуулалтын байнгын хорооны хуралдаанд тухайн Байнгын хороонд харьяалагдах нийт гишүүний гуравны хоёроос доошгүй ирцтэй бол түүнийг Монгол Улсын Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийн төслийг хэлэлцэхэд хүчин төгөлдөр буй гэж үзнэ гэж заасан байна.

Ирц хүрэлцэн ирсэн, Улсын Их Хурлын гишүүн, Төрийн байгуулалтын байнгын хорооны гишүүн Амарсайхан, Баатарбилэг, Бямбацогт, Ганбаатар, Ганболд, Мөнхбат, Мөнх-Оргил, Мөнхцэцэг, Нямбаатар, Оюунчимэг, Сүхбаатар, Тогтохсүрэн, Энхболд нарын гишүүд хүрэлцэн ирсэн ирц бүрдсэн байна.

Журмын тухай хуулийн 18.9-д Төрийн байгуулалтын байнгын хороо нэгдсэн хуралдаанаар дэмжигдсэн саналыг нэгтгэн Монгол Улсын Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийн төсөл болгон эцсийн хувилбарыг бэлтгэсэн санал, дүгнэлтийн хамт нэгдсэн хуралдаанд оруулна гэсэн ийм хуулийн журмын хуулийн зохицуулалттай.

Дэгийн хуулийн 54^{1}.3-т Монгол Улсын Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийн төслийг Байнгын хороо болон нэгдсэн хуралдаанаар хэлэлцэхэд гишүүний асуулт асуух хугацаа 5 минутаас илүүгүй, нэмэлт асуулт асуух хугацаа 1 минутаас илүүгүй, гишүүний асуултад хариулах хугацаа 5 минутаас илүүгүй, нэмэлт хариулт тайлбар өгөх хугацаа 1 минутаас илүүгүй, гишүүн үг хэлэх хугацаа 5 минутаас илүүгүй байна гэж заасан.

Ингээд Байнгын хорооны хоёр дахь хэлэлцүүлэгт бэлтгэсэн төслийг та бүхэнд тараасан байгаа.

Асуух асуулттай гишүүн байна уу. Алга байна.

Үг хэлэх гишүүн байна уу. Алга байна.

Монгол Улсын Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийн төслийн хоёр дахь хэлэлцүүлгийг явуулж дууслаа.

Санал хураадаг юм байхгүй. Чуулганы эцсийн хэлэлцүүлэг хийж байгаатай адилхан.

Ингээд Байнгын хорооны санал, дүгнэлтийг чуулганы нэгдсэн хуралдаанд миний бие танилцуулна.

Төрийн байгуулалтын байнгын хорооны хэлэлцэх асуудал дууссан тул энэ өдрийн хуралдаан хаасныг мэдэгдье.

Гишүүд, ажлын хэсэгт баярлалаа.

Дууны бичлэгээс буулгасан:
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ
ХӨТЛӨХ АЛБАНЫ ШИНЖЭЭЧ П.ОЮУНГЭРЭЛ